

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

245. Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай Дугаар 10 1110

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

246. Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай Дугаар 11 1113

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

247. Журам шинэчлэн батлах тухай Дугаар 211 1113

ЗАНГАГА

1. ᠒᠐᠒᠒
 ᠒. ᠒᠐᠒᠒
 3. ᠒᠐᠒᠒

᠐᠖᠖᠖

᠐᠖᠖᠖

1. ᠒᠐᠒᠒
 2. ᠒᠐᠒᠒
 3. ᠒᠐᠒᠒

᠖᠖

᠓᠐᠖᠖᠖

1. ᠒᠐᠒᠒
 2. ᠒᠐᠒᠒
 3. ᠒᠐᠒᠒

᠖᠖᠓

᠓᠐᠖᠖᠖



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр
сарын 07-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар
хот

Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай

Чөлөөт бүсийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр дэх “Чингис хаан” Олон улсын шинэ нисэх буудлыг түшиглэн “Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс” байгуулсугай.

2.Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсийн газрын талбайн хэмжээг 1000 га-аар тогтоож, газрын байршил, хилийн заагийн эргэлтийн цэгийн солбицлыг хавсралтаар баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Монгол Улсын Их Хурлын 2022 оны
10 дугаар тогтоолын хавсралт

ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН НУТАГ ДЭВСГЭР ДЭХ ХӨШИГИЙН ХӨНДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БҮСИЙН ГАЗРЫН БАЙРШИЛ, ХИЛИЙН ЗААГИЙН ЭРГЭЛТИЙН ЦЭГИЙН СОЛБИЦОЛ, ТАЛБАЙН ХЭМЖЭЭ

Сумын нэр	Солбицол							Талбайн хэмжээ
	Цэгийн дугаар	Өргөрөг			Уртраг			
		Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд	
Сэргэлэн	1	47	40	28.913	106	43	18.490	1000 га
	2	47	41	19.362	106	43	19.484	
	3	47	41	5.750	106	45	34.631	
	4	47	40	20.043	106	47	26.322	
	5	47	39	47.161	106	47	11.224	
	6	47	39	37.642	106	47	9.491	
	7	47	39	26.460	106	47	5.169	
	8	47	39	32.171	106	46	35.747	



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 02 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Европын Холбооны дэргэд суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Одын Очийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Европын Холбооны дэргэд суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Лувсанвандангийн Болдыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 7 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 211

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Өрийн удирдлагын тухай хуулийн 29.9-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийн эх үүсвэрийг зориулалтын дагуу үр дүнтэй ашиглах, дамжуулан зээлдүүлэх зээлийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу төлөх, зээлийг эргэн төлөх хөрөнгийн эх үүсвэрийг эцсийн зээлдэгч болон дэд зээлдэгч нь жил бүрийн төсөвтөө тусган журмыг хэрэгжүүлж ажиллахыг төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай.



4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2006 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 185 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

Засгийн газрын 2021 оны 211 дүгээр
тогтоолын хавсралт

**ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛЛЭГИЙН ХӨРӨНГИЙГ
ДАМЖУУЛАН ЗЭЭЛДҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар Засгийн газрын гадаад зээллэг, тухайн зээллэгтэй холбоотой буцалтгүй тусламж (цаашид “гадаад эх үүсвэр” гэх)-ийн болон дотоод эх үүсвэрээс бүрдүүлсэн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх нөхцөл, шаардлагыг тогтоож, дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээ байгуулах, гэрээнд оролцогч талуудын үүрэг, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, төлбөр, тооцоо бүртгэх, тайлагнах, гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах, хяналт тавих, хариуцлага тооцохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэхэд Иргэний хууль, Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль болон тухайн гадаад зээллэгийн батлагдсан гэрээ, холбогдох бусад хууль тогтоомж болон энэ журмыг мөрдөнө.

Хоёр.Дамжуулан зээлдүүлэх зээл олгох
урьдчилсан нөхцөл, шаардлага

2.1.Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэхэд тавигдах шаардлагыг Өрийн удирдлагын тухай хуулийн 29.3-29.8-д зааснаар зохицуулна.

2.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн гадаад зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг

эрсдэлийн үнэлгээний хамтаар Засгийн газарт хүргүүлж, хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

Гурав.Дамжуулан зээлдүүлэх зээлийн
гэрээ байгуулах

3.1.Энэ журмын 2.2-т заасан Засгийн газрын шийдвэрийн дагуу гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэхээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээг байгуулна.

3.2.Дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний нөхцөлийг тогтооходоо Өрийн удирдлагын тухай хууль болон энэ журамд заасан нөхцөл, шаардлагын дагуу гадаад зээллэгийн гэрээний нөхцөлтэй нийцүүлнэ.

3.3.Дэд болон эцсийн зээлдэгч нь гадаад зээллэгийн гэрээ, хэлэлцээрт урьдчилан тохирсон нөхцөл, шаардлагыг тусган энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан гэрээний загварын дагуу дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний төслийг боловсруулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.4.Дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээг 3 болон түүнээс дээш талын оролцоотой байгуулахаар бол гэрээ байгуулах хүсэлтийг талууд хамтран гаргаж, төсвийн ерөнхийлөн захирагчаар дамжуулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний төслийг хянан үзэж, оролцогч талуудтай санал солилцсоны үндсэн дээр ажлын 15 хоногт багтаан байгуулах эсхүл гадаад зээллэгийн гэрээ Улсын Их Хурлаар соёрхон батлагдах өдрөөр хүчин төгөлдөр болсноор дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээг байгуулж болно.

3.6.Дамжуулан зээлдүүлэх зээлийн ерөнхий нөхцөлийг тогтооходоо тухайн гадаад зээллэгийн анх авсан валютад үндэслэн тооцох бөгөөд дамжуулан зээлдүүлэх зээлийн үндсэн хүү болон эрсдэлийн шимтгэлийн төлбөрийг энэ журам болон гэрээнд өөрөөр заагаагүй бол анх авсан валютаар дамжуулан зээлдүүлэх талаар зээлийн гэрээнд тусгана.

3.7.Гадаад зээллэгийн гэрээнд заасан хүүгийн хувь дээр эрсдэлийн үнэлгээг үндэслэн 0.75-2.75 хүртэлх эрсдэлийн шимтгэлийн хувийг нэмж, эцсийн зээлдэгчийн эргэн төлөх хүү болон эрсдэлийн шимтгэлийн хувийг дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээнд тусгана.

3.8.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээ байгуулахдаа барьцааны болон батлан даалтын гэрээг Иргэний хуульд нийцүүлэн байгуулж болох бөгөөд тэдгээр гэрээ нь дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний салшгүй нэг хэсэг байна.

3.9.Дамжуулан зээлдүүлэх зээлийн үлдэгдлийг төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл дэх санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгалын тооцооллоор зээлийн хөрөнгийг эргэн төлөх чадвартайг нотлон харуулсан төсөвт өртөг буюу анхны хөрөнгө оруулалтын дүнд үндэслэн тогтооно.

3.10.Дамжуулан зээлдүүлэх зээлийг гадаад зээллэгийн гэрээнд тохиролцсоноос өөр валютаар зээлдүүлэх тохиолдолд тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газарт уламжлан Улсын Их Хурлаар шийдвэрлүүлэх ба ханшийн зөрүүгээс үүсэх эрсдэлийг Өрийн удирдлагын тухай хуулийн 30.6-д заасны дагуу улсын төсөвт дарамт учруулахгүй байх зарчмыг баримтлан эцсийн зээлдэгч бүрэн хариуцна.

3.11.Монгол Улсын Хөгжлийн банк, арилжааны банк болон бусад санхүүгийн байгууллага нь эцсийн зээлдэгчид дамжуулан зээлдүүлэх зээлийн хөрөнгийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгохдоо хүүгийн хувийг зах зээлийн хүүгээс ихгүй, үндсэн гадаад зээллэгийн гэрээнд туссан хүүгийн хувь хэмжээтэй уялдуулан тогтоосон байна.

Дөрөв.Дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээнд
оролцогч талуудын эрх, үүрэг

4.1.Дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний оролцогч талууд Өрийн удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан үүргийг хүлээнэ.

4.2.Эцсийн зээлдэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас бусдад учруулсан хохирол болон гуравдагч этгээдийн өмнө хүлээх үүргийг эцсийн зээлдэгч бүрэн хариуцна.

4.3.Жил бүр эцсийн зээлдэгч нь өөрийн байгууллагын төсөвт дараахь зүйлсийг тусгуулан харьяалах дэд зээлдэгч буюу төсвийн ерөнхийлөн захирагчид саналыг хүргүүлэн төсөвт батлуулах үүрэгтэй:

4.3.1.дамжуулан зээлдүүлэх зээлийн өрийн үйлчилгээний төлбөр;

4.3.2. дамжуулан зээлдүүлэх зээлийн тухайн төсвийн жилд авч ашиглах ашиглалт.

4.4. Дэд зээлдэгч нь дамжуулан зээлдүүлэх зээлийн өрийн үйлчилгээний төлбөрийг эцсийн зээлдэгчийн тухайн жилийн байгууллагын төсөвт тусгуулах, хяналт тавих үүрэгтэй.

4.5. Дамжуулан зээлдүүлэх зээлийн өрийн үйлчилгээний төлбөрийг дэд болон эцсийн зээлдэгчийн төсөвт тусгаж батлаагүй нь Өрийн удирдлагын тухай хуулийн 32.6-д заасныг хэрэгжүүлэхгүй байх үндэслэл болохгүй.

4.6. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Өрийн удирдлагын тухай хуулийн 32.6-д заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийг үндэслэх ба энэ талаар дэд болон эцсийн зээлдэгчид урьдчилж мэдэгдсэн байна.

4.7. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь эцсийн зээлдэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр эцсийн зээлдэгчийн нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтыг дамжуулан зээлдүүлэх зээлийн үлдэгдэлд суутган тооцож болно.

Тав. Дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн байгуулах болон гэрээний үүрэг дуусгавар болох

5.1. Дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээнд заасан зээлийн дүнгээс их, эсхүл бага хэмжээгээр ашигласан эсхүл зээлийн төлбөрийг урьдчилж төлсөн тохиолдолд дамжуулан зээлдүүлэх зээлийн үлдэгдлийн гүйцэтгэлд үндэслэн гэрээний эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулж болно.

5.2. Дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээг байгуулснаас хойш дараахь нөхцөл байдал үүссэн тохиолдолд гэрээг шинэчлэн байгуулна:

5.2.1. Өрийн удирдлагын тухай хуулийн 32.3-т заасны дагуу Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэсэн тохиолдолд;

5.2.2. эцсийн болон дэд зээлдэгч бүтцийн өөрчлөлтөд орох, эсхүл татан буугдах тохиолдолд.

5.3. Энэ журмын 5.1, 5.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Өрийн удирдлагын тухай хуулийн 30.7-д заасныг мөрдлөг болгоно.

5.4.Дэд болон эцсийн зээлдэгч энэ журмын 5.2.2-т заасан тохиолдолд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад нэн даруй мэдэгдэж, энэ журамд заасан холбогдох арга хэмжээг авах үүрэгтэй.

5.5.Гадаад зээллэгийн хөрөнгийн эх үүсвэрийг ашиглан төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэх явцад дараахь нөхцөл байдал үүссэн тохиолдолд уг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч талууд харилцан тохиролцож, тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээг нөхөн байгуулах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг шинэчлэн байгуулах эсэх асуудлыг шийдвэрлүүлнэ:

5.5.1.гадаад зээллэгийн хөрөнгийн эх үүсвэрийг ашиглан хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн эхэн, дунд, төгсгөл үед эцсийн зээлдэгч болон өмчлөгч, өр төлбөрийг хариуцагч этгээд тодорхой болоогүй;

5.5.2.төсөл хэрэгжүүлэгч нь гадаад зээллэгийн хөрөнгийг авч ашиглаж, өмчлөгч, өр төлбөрийг хариуцагч этгээд болох нь тодорхой боловч дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээ байгуулагдаагүй, дэд болон эцсийн зээлдэгчийг тодорхойлоход өр төлбөрийн маргаан үүссэн.

5.6.Дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээгээр хүлээсэн үүрэг дуусгавар болоход дараахь арга хэмжээг авна:

5.6.1.гэрээнд оролцогч талууд хамтран гэрээг дүгнэнэ;

5.6.2.гэрээг дүгнэхэд тэмдэглэл үйлдэн, гарын үсэг зурж баталгаажуулна;

5.6.3.гэрээгээр хүлээсэн үүрэг хангасан эсэх талаар дүгнэлт гаргана;

5.6.4.гэрээний үүрэг дуусгавар болсноор дамжуулан зээлдүүлэх зээлийг хаасан тухай мэдэгдлийг зээлдүүлэгчээс дэд болон эцсийн зээлдэгчид хүргүүлнэ.

5.7.Дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээгээр хүлээсэн үүргийг дараахь нөхцөл хангагдсан тохиолдолд дуусгавар болсонд тооцно:

5.7.1.гэрээний дагуу хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн тухай оролцогч талуудын шийдвэр гарсан;

5.7.2.гэрээтэй холбоотой ямар нэг өр төлбөргүй байх.

Зургаа.Бүртгэл, тайлагналт

6.1.Дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээгээр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээг санхүүгийн тайланд дараахь байдлаар бүртгэнэ:

6.1.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь:

6.1.1.1.дамжуулан зээлдүүлэх зээлийн ашиглалтыг санхүүжүүлэгч байгууллагаас ирүүлсэн ашиглалтын мэдэгдэл болон дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний хүлээх үүргийг гэрээний валютаар тооцож үлдэгдлийг Монголбанкны валютын тухайн өдрийн ханшаар бодож дэд эсхүл эцсийн зээлдэгчээс авах авлагаар Засгийн газрын авлагын тайланд бүртгэнэ;

6.1.1.2.дамжуулан зээлдүүлэх зээлийн ашиглалтыг санхүүжүүлэгч байгууллагаас ирүүлсэн ашиглалтын мэдэгдэлд зээлийн ашиглалт гарсан өдрөөр бүртгэнэ;

6.1.1.3.дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээ нь үндсэн гадаад зээллэгийн гэрээнээс өөр валютаар хийгдсэн бол санхүүжүүлэгч байгууллагаас ирүүлсэн ашиглалтын мэдэгдэлд зээлийн ашиглалт гарсан өдрийн ханшаар тухайн олгосон валютад хөрвүүлж бүртгэнэ;

6.1.1.4.дамжуулан зээлдүүлэх зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг гүйцэтгэхэд тухайн төлбөр хийгдсэн өдрийн ханшаар тооцож бүртгэх бөгөөд валютын ханшийн зөрүүгээс үүсэх эрсдэлийг эцсийн зээлдэгч бүрэн хариуцна;

6.1.1.5.дэд болон эцсийн зээлдэгч нь гэрээний үүргээ биелүүлээгүйгээс шалтгаалан үүссэн маргааныг шүүх эцэслэн шийдвэрлэсэн тохиолдолд шүүхийн шийдвэр, уг шийдвэрийг гүйцэтгэх хуудаст дурдсан дүнгээр Засгийн газрын авлагын тайланд эцсийн зээлдэгчээс авах авлагаар бүртгэнэ.

6.1.2.Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь:

6.1.2.1.дамжуулан зээлдүүлэх зээлийн ашиглалтыг санхүүжүүлэгч байгууллагаас төсөл хэрэгжүүлэгч нэгжийн дансанд орж ирсэн өдрөөр орлого хэлбэрээр бүртгэнэ;

6.1.2.2.төсөл хэрэгжүүлэгч нэгж нь гүйцэтгэл гарсан өдрөөр зарлага хэлбэрээр бүртгэнэ;

6.1.2.3.дамжуулан зээлдүүлэх зээлийн эх үүсвэрээс бий болсон хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгч нэгжийн тайланд хуримтлуулан бүртгэхгүй;

6.1.2.4.төсөл хэрэгжүүлэгч нэгж нь эцсийн зээлдэгчид сарын мэдээг сар бүрийн 5-ны өдрийн дотор хүргүүлж, хүлээн зөвшөөрч хуримтлуулан бүртгэх боломжоор хангана.

6.1.3.Эцсийн зээлдэгч нь:

6.1.3.1.гадаад зээллэгийн хөрөнгийн эх үүсвэрийг дамжуулан зээлдүүлэх зээлийн ашиглалт гарсан өдрөөс эхлэн хүлээн зөвшөөрч, хуримтлуулан санхүүгийн тайланд бүртгэнэ;

6.1.3.2.энэ журмын 6.1.3.1-д заасан хөрөнгийн эх үүсвэрийг бүртгэхдээ заавал өр төлбөрийн болон ханшийн зөрүүгээс үүсэх ашиг, алдагдлыг бүрэн тооцож, хамт бүртгэх бөгөөд иж бүрэн тайлагнана.

6.2.Дамжуулан зээлдүүлэх зээлийн хөрөнгийн эх үүсвэрээр бий болсон хөрөнгийг санхүүгийн тайланд бүртгэж, бүрэн тайлагнаагүй тохиолдолд тухайн эцсийн зээлдэгчийн санхүүгийн тайланг аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн цахим тайлан (e-balance)-д санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталгаажуулахгүй байх үндэслэл болно.

6.3.Санхүүгийн тайланг аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн цахим тайлан (e-balance)-д баталгаажуулаагүйгээс үүсэх үр дагаврыг дэд зээлдэгч, эцсийн зээлдэгч хамтран хариуцна.

6.4.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гадаад зээллэгийн хөрөнгийн эх үүсвэрээр олж авсан хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө нь тэдгээрийн өмчийн болон хариуцлагын хэлбэрээс хамааран төрийн болон орон нутгийн өмчид бүртгэгдэх бөгөөд дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээ дуусгавар болох хүртэл эцсийн зээлдэгчийн санхүүгийн тайланд өглөг хэлбэрээр бүртгэгдэнэ.

6.5.Дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний оролцогч талуудын хооронд түүний хэрэгжилттэй холбоотой үүссэн аливаа маргааныг шийдвэрлэхдээ тухайн дамжуулан зээлдүүлэх зээлийг дэд болон эцсийн зээлдэгч буцаан төлөх үндэслэлгүй тухай арбитр эсхүл шүүхийн шийдвэр гарсан бол уг шийдвэрийг үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дамжуулан зээлдүүлэх зээлийн авлага болон холбогдох бүртгэлээс хасаж тооцно.

6.6.Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу дэд зээлдэгч нь дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээ байгуулсан эцсийн зээлдэгчийн санхүүгийн тайланд гадаад зээллэгийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний санхүүгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу бүртгэсэн эсэхэд хяналт тавьж, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэж, тайлагнана.

6.7.Дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээнд оролцогч талууд гэрээ байгуулсан өдрөөс эхлэн энэ журмын 2 дугаар хавсралтад заасан загварын дагуу жилд 2-оос доошгүй удаа тооцоо нийлж, акт үйлдэн баталгаажуулна.

6.8.Дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээнд оролцогч талууд болон төсөл хэрэгжүүлэгч нэгж нь дараахь хугацааны дагуу хоорондын тооцоог тулган баталгаажуулна:

6.8.1.дамжуулан зээлдүүлэх зээлийн зээлдүүлэгч болон эцсийн зээлдэгчтэй тооцоо нийлэх өдрийг харилцан тохиролцон тогтоож, хагас жилийн байдлаар эргэн төлөлт, үлдэгдлийг жил бүрийн 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор;

6.8.2.жилийн эцсийн байдлаар эргэн төлөлт, үлдэгдлийг дараа жилийн 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор;

6.8.3.төсөл, арга хэмжээ хэрэгжиж байх хугацаанд төсөл хэрэгжүүлэгч нэгж нь дамжуулан зээлдүүлэх зээлийн ашиглалт, гүйцэтгэлээр дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээнд оролцогч талуудыг оролцуулан тооцоо нийлнэ.

6.9.Эцсийн зээлдэгч нь дамжуулан зээлдүүлэх зээлийн ашиглалтын мэдээг, дансны хуулгын хамт дараа сарын 2-ны өдрийн дотор, үлдэгдлийн тайланг улирал, хагас жил тутам гаргаж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын өрийн удирдлагын нэгжид ирүүлнэ.

6.10.Дамжуулан зээлдүүлэх зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд хяналт тавьсны үндсэн дээр санхүүжилт хийгдэнэ.

6.11.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь авлагын нэгдсэн мэдээллийг Өрийн удирдлага, санхүүгийн шинжилгээний систем (DMFAS)-д бүртгэнэ.

6.12.Өрийн удирдлага, санхүүгийн шинжилгээний систем (DMFAS)-д дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний дугаар, нөхцөл,

эргэн төлөлтийн хуваарь, ашиглалт, эргэн төлөлт, үлдэгдлийн талаарх мэдээллийг бүх төрлийн төлбөр хийгдэх болон мэдээлэлд нэмэлт, өөрчлөлт орох бүрд бүртгэнэ.

6.13.Өрийн удирдлага, санхүүгийн шинжилгээний систем (DMFAS)-ээс дараахь мэдээ, тайлан болон холбогдох бусад мэдээллийг шаардагдах тухай бүр нь боловсруулан гаргана:

6.13.1.дамжуулан зээлдүүлэх зээлийн хагас жил, жилийн эцсийн тайлан;

6.13.2.дамжуулан зээлдүүлэх зээлийн ашиглалтын мэдээ;

6.13.3.дамжуулан зээлдүүлэх зээлийн эргэн төлөлтийн мэдээ;

6.13.4.эцсийн зээлдэгчид хүргүүлэх төлбөрийн нэхэмжлэх;

6.13.5.шаардлагатай бусад дэлгэрэнгүй мэдээлэл.

6.14.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын өрийн удирдлагын нэгж нь эцсийн зээлдэгчийн нэрээр дамжуулан зээлдүүлэх зээлийн хувийн хэрэг нээж, түүнтэй холбоотой дараахь баримт бичиг, мэдээллийг уг хувийн хэрэгт хадгална:

6.14.1.дамжуулан зээлдүүлэх зээлийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр санал болгосон төсөл, арга хэмжээний анхны судалгаа, техник, эдийн засгийн үндэслэл, бусад холбогдох мэдээлэл;

6.14.2.гадаад зээллэгийн гэрээ;

6.14.3.дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээ, барьцаа, батлан даалтын гэрээ (хэрэв энэ төрлийн гэрээ хийгдсэн бол), түүний хавсралтууд;

6.14.4.дэд зээлдэгчтэй холбоотой мэдээллүүд;

6.14.5.тухайн дамжуулан зээлдүүлэх зээлийн талаарх танилцуулга;

6.14.6.дамжуулан зээлдүүлэх зээлтэй холбогдох этгээдийн хооронд харилцсан албан бичиг;

6.14.7.эрх бүхий этгээдийн шийдвэр;

баримтууд; 6.14.8.нэхэмжлэх, тооцоо нийлсэн акт, төлбөрийн

тэмдэглэл; 6.14.9.гэрээ байгуулахтай холбоотой хурал, уулзалтын

6.14.10.холбогдох бусад.

6.15.Дэд зээлдэгч арилжааны банк, бусад санхүүгийн байгууллага бол хувийн хэргийг дэд зээлдэгч бүрээр хөтөлнө.

6.16.Эцсийн зээлдэгч гэрээгээр хүлээсэн төлбөрийн үүргээ бүрэн төлж барагдуулж, гэрээ дуусгавар болсны дараа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын өрийн удирдлагын нэгж нь дамжуулан зээлдүүлэх зээлийн хувийн хэргийг архивын нэгж болгон, архивд шилжүүлнэ.

Долоо.Гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах,
түүнд хяналт тавих

7.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нь дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний хэрэгжилтэд Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хяналт тавина.

7.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний үндсэн дээр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдэж байгаа ажил, бүтээн байгуулалт, эд хөрөнгийн ашиглалт, бусад холбогдох үйл ажиллагааны явцтай биечлэн танилцаж болно.

Найм.Дамжуулан зээлдүүлэх зээлийн төлбөрийг гүйцэтгэх,
төлбөрийг төлөөгүй буюу гэрээний үүргийг биелүүлээгүй
тохиолдолд хариуцлага тооцох

8.1.Засгийн газрын дамжуулан зээлдүүлэх зээлийн төлбөрийг төгрөгөөр төлөх тохиолдолд эцсийн зээлдэгч нь гэрээнд заасан хуваарийн дагуу үндсэн болон хүүгийн төлбөрийг төлбөр төлөх өдрөөс нэг өдрийн өмнө Монголбанкны хаалтын ханшаар төгрөгт хөрвүүлэн тооцно.

8.2.Эцсийн зээлдэгч нь гэрээнд заасан хугацаанаас өмнө дамжуулан зээлдүүлэх зээлийн төлбөрийг эргүүлэн төлж болох бөгөөд энэ тохиолдолд эргэн төлөлтийн хуваарийн дагуу тооцсон нийт үндсэн төлбөр,

төлбөр барагдуулах өдөр хүртэл тооцсон хүүг тооцоо нийлэн, тулган баталгаажуулсны дараа төлбөрийг төлбөр төлөх өдрийн Монголбанкны хаалтын ханшаар гүйцэтгэнэ.

8.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас дамжуулан зээлдүүлэх зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлбөрийн нэхэмжлэхийг зээлдэгч байгууллагад хүргүүлнэ.

8.4.Төлбөрийн нэхэмжлэхийг төлбөр төлөх хуваарьт өдрөөс 30 хоногийн өмнө цахим шуудангаар эсхүл албан бичгээр хүргүүлнэ. Албан бичгийг шууданд хийснээр албан ёсоор хүргүүлсэнд тооцно.

8.5.Зээлдүүлэгчээс төлбөрийн нэхэмжлэхийг хугацаандаа хүргүүлээгүй нь эцсийн зээлдэгч гэрээгээр хүлээсэн төлбөрийн үүргээ хугацаанд нь төлөхгүй байх үндэслэл болохгүй.

8.6.Дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээнд заасан төлбөр төлөх хуваарьт өдрөөс 3 болон түүнээс дээш сараар төлбөрийг хэтрүүлсэн, эсхүл дутуу төлсөн тохиолдолд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэх үндэслэл болно:

8.6.1.эцсийн зээлдэгчийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эргэн төлөлтийн хуваарийг зөрчсөн тухай дэд зээлдэгчид мэдэгдэж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хариу ирүүлэхийг шаардана;

8.6.2.дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу дараалсан хоёр төлбөрийг хугацаандаа барагдуулаагүй тохиолдолд шүүхэд нэхэмжлэл гаргана.

8.7.Эцсийн зээлдэгч нь төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд гэрээнд заасан алданги тооцно.

8.8.Алдангийг дараахь байдлаар тооцно:

8.8.1.гэрээнд өөрөөр заагаагүй бол хугацаа хэтэрсэн өр төлбөрийн үлдэгдэл дүнд алдангийн төлбөрийг тооцно;

8.8.2.алдангийг үндсэн болон хүүгийн төлбөрийн гүйцэтгээгүй хоног тутамд тооцно;

8.8.3.алдангийн хувь хэмжээг тогтоохдоо 0.5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр тогтооно.

8.9. Дамжуулан зээлдүүлэх зээлийн төлбөрийг дараахь дарааллаар хасалт хийж тооцно:

8.9.1. алданги;

8.9.2. хүү болон эрсдэлийн шимтгэлийн төлбөр;

8.9.3. үндсэн төлбөр.

8.10. Алдангийг хөнгөлөх, чөлөөлөх талаар ирүүлсэн саналд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь холбогдох санал, дүгнэлтийг гаргаж, шийдвэрлэх бөгөөд шаардлагатай гэж үзвэл уг асуудлыг Засгийн газарт танилцуулна.

8.11. Эцсийн зээлдэгч нь дамжуулан зээлдүүлэх зээлийн хөрөнгийн эх үүсвэрийг зориулалт бусаар ашигласан, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл чанарын шаардлагад нийцээгүй, хэмжигдэхүйц бус, дамжуулан зээлдүүлсэн зээл үр дүнгүй болон Өрийн удирдлагын тухай хууль, энэ журам, дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээ, бусад хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд дараахь арга хэмжээг авна:

8.11.1. дамжуулан зээлдүүлэх зээлийн гадаад талын санхүүжилтийг хэсэгчлэн хаах, эсхүл бүрэн хэмжээгээр зогсоох;

8.11.2. тухайн төсөл, арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх эрхийг түдгэлзүүлэх.

8.12. Дэд болон эцсийн зээлдэгч нь дамжуулан зээлдүүлэх зээлийн хөрөнгийн эх үүсвэрээр бий болсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хадгалж, хамгаалах үүрэгтэй бөгөөд дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний үүргээ бүрэн хэрэгжүүлж дуусах хүртэл тус эд хөрөнгийг бусдад шилжүүлэх, устгах, үгүй хийхийг хориглоно.

8.13. Дамжуулан зээлдүүлэх зээлийн хөрөнгийн эх үүсвэрээр бий болсон эд хөрөнгийг бусдад шилжүүлэх тохиолдолд дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээг шинэчлэн байгуулж болох ба энэ нь анх дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээ байгуулсан эцсийн зээлдэгчийн ашигласан хугацаанд ногдох төлбөрөөс татгалзах үндэслэл болохгүй.

Ес. Бусад

9.1. Дэд зээлдэгч буюу төсвийн ерөнхийлөн захирагч нь дамжуулан зээлдүүлэх зээлийн хүрээнд хэрэгжих төсөл, арга хэмжээ болон бий болсон бүтээн байгуулалтыг эцсийн зээлдэгчийн өмчлөлд шилжүүлэх асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хандан шийдвэрлүүлнэ.

9.2.Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

9.3.Засгийн газрын дамжуулан зээлдүүлэх зээлтэй холбогдолтой мэдээллийг олон нийтэд мэдээлэх, ил тод байдлыг хангах, тайлагнахдаа Өрийн удирдлагын тухай хууль, Шилэн дансны тухай болон бусад холбогдох хууль, журмыг мөрдлөг болгоно.

9.4.Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас үүссэн эрсдэлийг холбогдох хууль тогтоомж болон дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээнд зааснаар зохицуулна.

9.5.Дамжуулан зээлдүүлэх зээлийн асуудлаар зээлдүүлэгч болон дэд зээлдэгч, эцсийн зээлдэгчийн хооронд гарсан аливаа маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд хэрэв шийдвэрлэх боломжгүй бол маргааныг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

9.6.Өрийн удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу дамжуулан зээлдүүлэх зээлийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал нь эцсийн зээлдэгч эрсдэлийн үнэлгээнд тэнцээгүйгээс хамаарч хэрэгжих боломжгүй болох эрсдэлийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцахгүй.

---o0o---

ЗЭЭЛИЙН ДУГААР:
ЗЭЭЛИЙН ЭХ ҮҮСВЭР:

“ТӨСЛИЙН НЭР”

САНГИЙН ЯАМ
/зээлдүүлэгч/

ба

...

/дэд зээлдэгч/
(гурвалсан гэрээ байгуулах тохиолдолд)

болон

...

/эцсийн зээлдэгч/

ХООРОНД БАЙГУУЛСАН

ДАМЖУУЛАН ЗЭЭЛДҮҮЛЭХ ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ

20..оны...дугаар сарын...-ны өдөр



БАТЛАВ:

САНГИЙН САЙД

..... САЙД

.....

.....

“ТӨСЛИЙН НЭР” -ийн зээлийн хөрөнгийг
дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээ

20.. оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

Энэхүү гэрээг нэг талаас САНГИЙН ЯАМ /цаашид “зээлдүүлэгч” гэх/, нөгөө талаас ... /цаашид “дэд зээлдэгч” гэх/, ... /цаашид “эцсийн зээлдэгч” гэх/ харилцан тохиролцож, Иргэний хуулийн 281-284 дүгээр заалт, Засгийн газрын 2021 оны ... дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх журам”, 20.. оны .. дугаар сарын ... -ний өдөр Монгол Улсын Засгийн газар ба хооронд байгуулсан “ТӨСЛИЙН НЭР”-ийн ... дугаартай зээлийн гэрээг үндэслэн байгуулав.

Ерөнхий зүйл

(А)Монгол Улсын Засгийн газар ба /цаашид “.....” гэх/ хооронд 20... оны ... дугаар сарын ... -ний өдөр байгуулагдсан зээлийн хэлэлцээрийн дагуу нь Монгол Улсад дээрх зээлийн хэлэлцээрт тусгагдсан нөхцөл, болзлын дагуу ... /... / зээлжих тусгай эрхтэй тэнцэх эх үүсвэр.

(Б)Засгийн газрын шугамаар авсан гадаадын зээлийг эргүүлэн төлөх дотоод эх үүсвэрийг бүрдүүлэх, зээлийн хэлэлцээрт тодорхойлсны дагуу “ТӨСЛИЙН НЭР” /цаашид “Төсөл” гэнэ/-ийг хэрэгжүүлэхэд зээлдэгчид энэхүү гэрээнд заасан нөхцөл болзлын дагуу зээлийн хөрөнгөөс дамжуулан зээлдүүлнэ.

(В)Зээлийн гэрээ ба “Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх журам”-д тодорхойлсон нэр томьёоны утга агуулга нь уг баримт бичгүүдэд тодорхойлсон тэрхүү утга агуулгаа энэхүү дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээнд нэгэн адил хадгална.

(Г)Энэхүү гэрээний хавсралт нь түүний салшгүй хэсэг мөн.

Нэгдүгээр зүйл.

Дамжуулан зээлдүүлэх зээлийн урьдчилсан нөхцөл

1.1.Зээлдүүлэгч нь зээлийн хөрөнгийг дараахь нөхцөл болзлын дагуу эцсийн зээлдэгчид дамжуулан зээлдүүлнэ:



1.1.1.зээлийн дүн: ... /.../ зээлжих тусгай эрх байна;

1.1.2.зээлийн хүү: жилийн ... хувь;

1.1.3.эрсдэлийн шимтгэл: жилийн ... хувь;

1.1.4.хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж: жилийн ... хувь, тогтмол байна. Зээлийн гэрээ байгуулагдсан өдрөөс эхлэн төсөл хэрэгжиж дуусах өдөр буюу ашиглалт бүрэн ашиглагдаж дуусах өдөр хүртэл ашиглаагүй зээлийн үлдэгдлээс тооцно;

1.1.5.төлбөр төлөх огноо: Эцсийн зээлдэгч нь зээлийн хүү, үндсэн төлбөр болон хөрөнгө нөөцөлсний хураамжийг жил бүрийн ... дугаар сарын ... ба ... дугаар сарын ... -ний өдөр зээлдүүлэгчид төлнө;

1.1.6.зээлийг төлж барагдуулах хугацаа: ... оны ... дугаар сарын ... -ний өдрөөс ... оны ... дугаар сарын ... -ний өдөр байна;

1.1.7.зээлийн үндсэн, хүү болон эрсдэлийн шимтгэлийн төлбөрийг тооцох хоног: Жилийн ... хоног, сарын ... хоногоор тооцно;

1.1.8.эргэн төлөлтийн хуваарь шинэчлэх: Эцсийн зээлдэгч нь төсөл хэрэгжиж дууссаны дараа зээлдүүлэгч болон эцсийн зээлдэгчийн хооронд тооцоо нийлсэн акт үйлдэх замаар ашигласан зээлийн хэмжээгээр зээлийн эргэн төлөлтийн хуваарийг шинэчлэн баталж энэхүү гэрээний салшгүй хэсэг болгон мөрдөнө;

1.1.9.алданги: хугацаа хэтэрсэн хоног тутамд ... хувь.

1.2.Энэхүү гэрээний аливаа заалтыг харгалзахгүйгээр зээлийн хэлэлцээрийн дагуу төсөлд зориулж хөрөнгө, эх үүсвэр шилжүүлж авах зээлдүүлэгчийн эрх бүхлээр буюу хэсэгчлэн зогсох, цуцлагдах эсхүл дуусгавар болох тохиолдолд эцсийн зээлдэгчийн зээлийн хөрөнгө, эх үүсвэр хүлээн авах эрх нэгэн адил зогсох, цуцлагдах эсхүл дуусгавар болно.

Хоёрдугаар зүйл.

Зээлийн эргэн төлөлтийг гүйцэтгэх

2.1.Эцсийн зээлдэгч зээлийн эргэн төлөлтийг энэхүү гэрээний хавсралтад дурдсан эргэн төлөлтийн хуваарийн дагуу дараахь зарчмыг баримтлан төлнө:



2.1.1.Зээлийн эргэн төлөлтийг Төрийн сан дахь “ДЗ (Дамжуулан зээлдүүлэх) тусгай данс” нэртэй 100900000711 тоот төгрөгийн дансанд шилжүүлнэ;

2.1.2.Үндсэн болон хүүгийн төлбөрийг тус тусдаа гүйлгээгээр дараахь товчилсон гүйлгээний утгаар шилжүүлнэ:

2.1.2.1.үндсэн төлбөрийг төлөхдөө “гэрээний дугаар-11” гэж;

2.1.2.2.хүүгийн төлбөрийг төлөхдөө “гэрээний дугаар-21” гэж.

2.2.Эцсийн зээлдэгч нь энэхүү гэрээгээр авсан зээлийн хөрөнгийг хугацаанаас нь өмнө буцааж төлөх боломжтой бөгөөд энэ тохиолдолд зээлийг урьдчилж төлөх тухай мэдэгдлийг төлбөр хийхээс 30 хоногийн өмнө зээлдүүлэгчид бичгээр мэдэгдэнэ.

Гуравдугаар зүйл.

Зээлдүүлэгчийн эрх үүрэг

3.1.Зээлдүүлэгч нь дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээг байгуулахын зэрэгцээ эцсийн зээлдэгчийн төсөл хэрэгжүүлэх зорилгоор энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхэд зээлдүүлэгчээс хамаарах бүхий л үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.

3.2.Энэхүү гэрээний 2.1-ийн дагуу хүлээсэн үүргээ бүрэн, эсхүл хэсэгчлэн биелүүлээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ... хувьтай тэнцэх алданги тооцож, эцсийн зээлдэгчийн төрийн сан (арилжааны банк) дахь ... данснаас үл маргах журмаар шууд суутган авах эрхтэй.

3.3.Хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрийг дор дурдсан дарааллаар хасалт хийж тооцно. Үүнд:

3.3.1.алданги;

3.3.2.хүүгийн болон эрсдэлийн шимтгэлийн төлбөр;

3.3.3.үндсэн төлбөр.

3.4.Эцсийн зээлдэгч зээлийг зориулалтын бусаар ашигласан, зээлийн төлбөрийг дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээнд заасан хугацаанд эргүүлэн төлөөгүй болон санхүүжилтийн хэлэлцээр, холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд зээлийг хэсэгчлэн эсхүл



бүрэн хэмжээгээр зогсоох, төсөл хэрэгжүүлэх эрхийг түдгэлзүүлэх, холбогдох албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар хүргүүлэх, шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

3.5.Энэ гэрээний хүрээнд зээлийн эргэн төлөлтөд хяналт тавих, эцсийн зээлдэгчтэй тооцоо нийлэх, дүнг баталгаажуулах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллана.

Дөрөвдүгээр зүйл.

Дэд зээлдэгчийн эрх үүрэг

4.1.Дэд зээлдэгч нь эцсийн зээлдэгчийн дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхэд хяналт тавина.

4.2.Зээлийн эх үүсвэрээр худалдан авсан хөрөнгийг эцсийн зээлдэгчид тогтвортой эзэмшүүлж ашиглуулах замаар орлогын эх үүсвэр, хуримтлал бий болгох бодлого баримталж, бүх талаар дэмжлэг үзүүлнэ.

4.3.Эцсийн зээлдэгч үүсгэн байгуулагдсан зорилтот үйл ажиллагаагаа зогсоох, татан буугдах зэрэг энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй хуульд заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд түүний төлбөрийн үүргийг гүйцэтгүүлэх арга хэмжээг хариуцан гүйцэтгэнэ.

4.4.Эцсийн зээлдэгчийн зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг эргүүлэн төлүүлэх үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.

Тавдугаар зүйл.

Эцсийн зээлдэгчийн эрх үүрэг

5.1.Эцсийн зээлдэгчийн нэр, байнгын хаяг:

Байгууллагын нэр
Хаяг
Утас
Факс
Цахим хуудас

5.2.Эцсийн зээлдэгч нь хариуцсан төслийг удирдлага, зохион байгуулалт, санхүү, инженер техник, байгаль орчин болон олон улсын стандартын хэм хэмжээний хүрээнд үр ашигтай хэрэгжүүлэх үүрэгтэй.

5.3.Эцсийн зээлдэгч нь дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээгээр олгосон хөрөнгийг зөвхөн санхүүжилтийн хэлэлцээрт заасан төслийн зориулалтаар ашиглана.

5.4.Зээлийн данснаас шилжүүлсэн төлбөрийг хүлээн авах тухай бүрд бодитоор гарсан зардлын анхан шатны баримтыг үндэслэн бүртгэл тайланд тусгана.

5.5.Эцсийн зээлдэгч нь зээлийн хөрөнгөөр авсан эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй бөгөөд зээлийн хөрөнгийг өөр зориулалтаар захиран зарцуулахыг хориглоно.

5.6.Эцсийн зээлдэгчийн зээлийн хөрөнгөөр авсан эд хөрөнгө нь төрийн өмчид хамаарах бөгөөд тайлан тэнцэлдээ хөрөнгөөр бүртгэж, дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээ дуусгавар болох хүртэл ашигласан зээлийн дүнг тайлан тэнцэлдээ өглөг хэлбэрээр бүртгэнэ.

5.7.Эцсийн зээлдэгчийн зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг жил бүр байгууллагын төсөвт суулгаж, эргүүлэн төлөх үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.

5.8.Байгууллагын төсөвт тусгагдаагүй шалтгаан нь Өрийн удирдлагын тухай хуулийн 31, 32 дугаар зүйлд заасны дагуу зээлийн эргэн төлөлтийг гүйцэтгэхгүй байх үндэслэл болохгүй.

5.9.Эцсийн зээлдэгч нь үндсэн болон хүүгийн төлбөр хийсэн тухай бүр зээлдүүлэгчид албан бичгээр мэдэгдэж хагас жил тутам тооцоо нийлж баталгаажуулах үүрэгтэй.

5.10.Эцсийн зээлдэгч үүсгэн байгуулагдсан зорилтот үйл ажиллагаагаа зогсоох, татан буугдах зэрэг тохиолдолд дамжуулан зээлдүүлсэн зээлийн үндсэн өрийн төлөгдөөгүй үлдэгдэл, тухайн үед хуримтлагдсан бүх хүүг нэн даруй зээлдүүлэгчид төлнө.

5.11.Эцсийн зээлдэгч дамжуулан зээлдүүлсэн зээлийн ашиглалтын явцын талаарх тайлан танилцуулгыг хагас, бүтэн жилээр гаргаж, зээлийн шугамаар нийлүүлэгдэх тоног, төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, бараа материалыг хүлээн авсан нийлүүлэлт, үлдэгдлийн мэдээ, тайланг тухай бүр зээлдүүлэгчид ирүүлнэ.

Зургадугаар зүйл.

Маргааныг шийдвэрлэх

6.1.Зээлдүүлэгч болон дэд зээлдэгч, эцсийн зээлдэгчийн хооронд гарсан аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцож, шийдвэрлэх бөгөөд хэрэв ийм шугамаар шийдвэрлэх боломжгүй бол маргааныг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Долдугаар зүйл.

Хүчин төгөлдөр, дуусгавар болох

7.1.Энэхүү гэрээ нь оролцогч талууд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

7.2.Зээлдүүлэгч холбогдох яам, газартай хамтран энэхүү гэрээг дүгнэж, эцсийн зээлдэгч уг зээлтэй холбогдох ямар нэг өр төлбөргүй болохыг тодорхойлсон дүгнэлт гаргаж, зээлийг хаасан тухай зээлдүүлэгчийн мэдэгдлийг эцсийн зээлдэгчид хүргүүлснээр энэхүү дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээ дуусгавар болсонд тооцно.

7.3.Эцсийн зээлдэгч нь өөрчлөн байгуулагдах тохиолдолд түүний энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг нь ийнхүү өөрчлөн байгуулагдсаны дүнд шинээр үүссэн хуулийн этгээдэд шилжинэ.

Наймдугаар зүйл.

Бусад

8.1.Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулах бөгөөд дамжуулан зээлдүүлсэн зээлийн өр төлбөрийг тайлан тэнцэлд зайлшгүй тусгана.

ЗЭЭЛДҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ДЭД ЗЭЭЛДЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ЭЦСИЙН ЗЭЭЛДЭГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГА

САНХҮҮГИЙН БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГА

Хавсралт №2
(Загвар)

Монгол Улсын Сангийн яам болон “....” дамжуулан зээлдүүлсэн зээлийн тооцоо нийлсэн акт 2020.12.31

(валютаар ...)

	Эхний үлдэгдэл 31.12.2019	Ашиглалт 01.01.2020 31.12.2020	Үндсэн төлбөр 01.01.2020 31.12.2020	Эцсийн үлдэгдэл 31.12.2020	Хүүгийн төлбөр 01.01.2020 31.12.2020	Хуримтлагдсан хүү 31.12.2020	Хугацаа хэтэрсэн үндсэн төлбөр 31.12.2020	Хугацаа хэтэрсэн хүүгийн төлбөр 31.12.2020
Зээлийн Дугаар								
Зээлийн Дугаар	Дүн	Дүн	Дүн	Дүн	Дүн	Дүн	Дүн	Дүн
Зээлийн Дугаар	Дүн	Дүн	Дүн	Дүн	Дүн	Дүн	Дүн	Дүн
Зээлийн Дугаар	Дүн	Дүн	Дүн	Дүн	Дүн	Дүн	Дүн	Дүн
Зээлийн Дугаар	Дүн	Дүн	Дүн	Дүн	Дүн	Дүн	Дүн	Дүн
Зээлийн Дугаар	Дүн	Дүн	Дүн	Дүн	Дүн	Дүн	Дүн	Дүн

Тооцоо нийлсэн актад дараахь албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулна:

Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг төлөөлж:

- Дамжуулан зээлдүүлэх зээлийн асуудал хариуцсан нэгжийн дарга;
- Дамжуулан зээлдүүлэх зээлийн асуудал хариуцсан нэгжийн бүртгэл, тайлагналт хариуцсан албан тушаалтан.

Дэд зээлдэгчийг төлөөлж:

- Холбогдох газар, хэлтсийн дарга;
- Эцсийн зээлдэгчийг хариуцсан албан тушаалтан.

Эцсийн зээлдэгчийг төлөөлж:

- Гүйцэтгэх захирал;
- Ерөнхий нягтлан бодогч, эсхүл санхүүгийн албаны дарга.

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийг төлөөлж:

- Төслийн зохицуулагч;
- Ерөнхий нягтлан бодогч, эсхүл санхүүгийн ажилтан.

---o0o---



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.75

Индекс: 200003